

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Хонгор сумын ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2026/02НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас:70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас:70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитор: Н.Отгонцэцэг Утас: 70378845 Цахим хаяг: otgontsetsegn@audit.gov.mn
Дархан-Уул аймаг 2026 он	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



### ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бүрэлтэй гудамж 1, 14 дугаар байр, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45055  
Утас: 7037-3669 Факс: (8765) 7037-3088  
Цахим илүүдэл: darhanuul@audit.gov.mn  
Цахим хуудал: www.audit.mn

2025.03.26 № 188

талаа \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ -т

ХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Н.ГАНБААТАР ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Хонгор сумын ТЕЗ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг охицлон тэмдэглэсэн хэсэг

Сумын орон нутгийн төсвөөс Монгол Улсын Сангийн яам болон Дархан-Уул аймгийн ЗДТГ хооронд байгуулсан Азийн хөгжлийн банкны эх үүсвэрээр хэрэгжсэн "Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төсөл"-ийн дамжуулан зээлийн өрөнд 954.8 сая төгрөгийг аймгийн төсөөт төвлөрүүлсэн байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд сумын төсвийн зарлагын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн төсөөт 7,882.1 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

## **Бусад асуудал**

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудитормын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулсан болно.

Төсвийн ерөнхийлөн захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Сумын Засаг даргын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, Хонгор сумын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг Хонгор сумын ИТХ-аар хэлэлцээд, 96.7 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ өнгид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБӨУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

ЦЭМӨНХБАЯР



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>4,755,256.5</b>	<b>3,300,740.4</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	1,837,346.7	1,773,572.0
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	2,086,418.4	575,050.5
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	612.5	-
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	830,878.9	952,118.0
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>14,673,245.1</b>	<b>16,796,569.7</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	14,673,245.1	16,796,569.7
39200	Биет хөрөнгө		13,210,798.0	15,332,082.2
39300	Биет бус хөрөнгө	13	1,462,447.1	1,464,487.5
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>		<b>19,428,501.6</b>	<b>20,097,310.2</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		268,774.9	1,448,239.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		268,774.9	1,448,239.1
41300	Өглөг		268,774.9	1,448,239.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		19,159,726.7	18,649,071.0
51	Засгийн газрын хувь оролцоо		19,159,726.7	18,649,071.0
51100	Засгийн газрын оруулсан капитал		2,438,353.5	2,438,353.5
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		945,252.5	945,252.5
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		4,835,484.7	7,359,759.0
51200	Хуримтлагдсан үр дүн		9,629,083.6	6,594,153.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,311,552.5	1,311,552.5
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>		<b>19,428,501.6</b>	<b>20,097,310.2</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>		<b>17,799,317.4</b>	<b>18,041,645.9</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>		9,880,815.7	12,828,955.0
110	Орлогын албан татвар		9,108,960.4	11,046,661.4
1100	Хувь хүний орлогын албан татвар		9,108,960.4	11,046,661.4
113	Хөрөнгийн албан татвар		298,657.9	546,060.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж		473,197.4	1,236,233.3
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	1а, 1б	1,185,297.6	5,212,690.9
122	Тусламжийн орлого		0.0	108,612.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		6,733,204.0	-
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	2а, 2б	<b>12,684,266.0</b>	<b>16,004,014.7</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		12,684,266.0	15,981,982.2
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		6,047,126.8	6,917,233.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,724,394.0	2,418,625.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		216,435.3	198,208.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,030,521.8	1,103,134.9
2104	Хангамж, бараа материалын зардал		180,419.0	159,783.9
2105	Нормативт зардал		2,380.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		212,155.3	121,041.5
2107	Томилолт, зочны зардал		14,920.0	11,284.1

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		621,462.7	501,408.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		2,044,438.5	2,403,746.6
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>6,637,139.3</b>	<b>9,064,748.4</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>0.0</b>	<b>22,032.5</b>
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		5,115,051.3	2,037,631.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		2,501,627.3	4,853,372.9
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		(2,501,627.3)	(4,853,372.9)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		2,613,424.1	(2,815,741.7)

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>16,244,227.1</b>	<b>19,586,462.0</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>9,880,815.7</b>	<b>12,828,955.0</b>
110	Орлогын албан татвар	9,108,960.4	11,046,661.4
113	Хөрөнгийн албан татвар	298,657.9	546,060.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж	473,197.4	1,236,233.3
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	114,043.1	190,569.3
1181	Газрын төлбөр	348,911.4	1,036,195.5
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	10,242.8	9,468.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,496,688.8	6,757,507.0
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,496,688.8</b>	<b>2,939,829.9</b>
122	Тусламжийн орлого	0.0	108,612.2
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	3,709,064.8
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>4,846,722.6</b>	<b>0.0</b>
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>11,421,113.8</b>	<b>14,496,182.9</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,421,113.8	14,496,182.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,775,260.9	5,431,434.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,998,174.2	2,447,124.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	324,536.5	198,208.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,039,983.0	1,114,169.4
2104	Хангамж, бараа материалын зардал	471,010.0	307,269.2
2105	Нормативт зардал	2,380.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	190,070.3	91,136.5
2107	Томилолт, зочны зардал	13,655.0	9,800.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	415,491.3	789,651.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	319,960.7	474,075.3
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>6,645,853.0</b>	<b>9,064,748.4</b>
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,803,113.3	5,090,279.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	4,801,895.1	5,054,753.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,801,895.1	5,054,753.8
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>4,801,895.1</b>	<b>5,054,753.8</b>
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(4,801,895.1)	(5,054,753.8)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	99,300.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	(99,300.0)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,218.2	(63,774.7)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,836,128.5	1,837,346.7
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,837,346.7	1,773,572.0

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
-----	----------	---------------------------------	-----------------------	-------------------	--

1	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	7,071,968.4	1,311,552.5	7,015,659.4	15,399,180.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,071,968.4	1,311,552.5	7,015,659.4	15,399,180.3
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,147,122.3	-	-	1,147,122.3
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	2,613,424.1	2,613,424.1
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,219,090.7	1,311,552.5	9,629,083.5	19,159,726.7
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	8,219,090.7	1,311,552.5	9,629,083.5	19,159,726.7
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(219,188.3)	(219,188.3)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,219,090.7	1,311,552.5	9,409,895.2	18,940,538.4
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	2,131,168.1	-	-	2,131,168.1
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	393,106.3	-	-	393,106.3
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(2,815,741.7)	(2,815,741.7)
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,743,365.0	1,311,552.5	6,594,153.5	18,649,071.0

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөгөөр /

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	19,901,075.6	17,753,028.9	(2,148,046.7)	89.2
1	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	16,780,863.2	17,407,781.6	626,918.4	103.7
11	Татварын орлого	12,568,698.1	12,828,955.0	260,256.9	102.1
12	Татварын бус орлого	4,212,165.1	4,578,826.6	366,661.5	108.7
120	Нийтлэг татварын бус орлого	503,100.4	869,761.8	366,661.4	172.9
120003	Торгуулийн орлого	395,982.3	740,544.4	344,562.1	187.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	106,418.1	128,516.4	22,098.3	120.8
120009	Бусад орлого	700.0	701.0	1.0	100.0
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	3,709,064.7	3,709,064.8	0.1	100.0
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	3,120,212.4	345,247.3	(2,774,965.1)	11.1
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	19,901,075.6	17,635,853.9	(2,265,221.7)	88.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,205,024.5	12,600,056.4	(604,968.1)	95.4

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,003,481.6	3,695,060.7	(308,420.9)	92.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,605,953.3	1,590,486.3	(15,467.0)	99.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	200,744.3	198,208.5	(2,535.8)	98.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,134,896.9	1,001,761.7	(133,135.2)	88.3
2104	Хангамж, бараа материалын зардал	96,318.7	82,052.7	(14,266.0)	85.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	113,694.1	107,860.6	(5,833.5)	94.9
2107	Томилолт, зочны зардал	9,875.0	9,800.0	(75.0)	99.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	244,207.2	191,105.6	(53,101.6)	78.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	597,792.1	513,785.3	(84,006.8)	85.9
212	ТАТААС	255,000.0	255,000.0	-	100.0
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	255,000.0	255,000.0	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,946,542.9	8,649,995.7	(296,547.2)	96.7
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	8,930,330.5	8,637,493.7	(292,836.8)	96.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,212.4	12,502.0	(3,710.4)	77.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,395,992.9	4,936,497.5	(1,459,495.4)	77.2
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	300,058.2	99,300.0	(200,758.2)	33.1
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,471,216.9		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,588,392.0		

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/ Гүйцэтгэл
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>65,950.7</b>
122	Тусламжийн орлого	65,950.7
1221	Хандив тусламж /дотоод/	65,950.7
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	<b>65,950.7</b>
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	65,950.7
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>65,950.7</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<b>65,950.7</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<b>65,950.7</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	<b>9,332.0</b>
210104	Урамшуулал	9,332.0
2104	Хангамж, бараа материалын зардал	<b>12,173.5</b>
210401	Бичиг хэрэг	719.5
210402	Тээвэр, шатахуун	4,779.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,200.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,475.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	<b>34,095.2</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,500.0
210602	Тавилга	2,500.0
210604	Урсгал засвар	12,095.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	<b>10,350.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	350.0

## Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар сумын ИТХ-д суудалтай намуудад орон нутгийн төсвөөс 125.0 сая төгрөгийн дэмжлэг олгосон зөрчил<sup>1</sup> илэрсэнд зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

### 3.1 Албан шаардлага

Өнгөрсөн оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс тайлант хугацаанд сумын ИТХ-д суудалтай улс төрийн намуудад орон нутгийн төсвөөс 125.0 сая төгрөгийн дэмжлэг олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан нь Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Нам дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 10.1.5-д “энэ хуулийн 34.6-д заасан хориглосон этгээдээс хандив, тусламж, санхүүжилт шууд болон шууд бусаар авах”, 34 дүгээр зүйлийн 34.6-д “Нам дараах этгээдээс хандив авахыг хориглоно”, 34.6.3-т “төрийн байгууллага болон нутгийн өөрөө удирдах байгууллага” гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй тул албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/сая төгрөгөөр/					
							Үүнээс		Зөвлөмж			
							Залруулсан				Залруулаагүй	
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
ЗДТГ	2	71.3	-	-	2	71.3	2	71.3	-	-	-	-
ОНХС	1	3,712.8	1	3,712.8			1	3,712.8				
ХХС	1	135.8			1	135.8	1	135.8				
“Хонгор хот тохижилт” ОНӨААТҮГ	1	174.1	-	-	1	174.1	1	174.1				
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>4,093.9</b>	<b>1</b>	<b>3,712.8</b>	<b>4</b>	<b>381.1</b>	<b>5</b>	<b>4,093.9</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		/сая төгрөгөөр/					
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Тоо	Дүн				
ЗДТГ	2	3.8	1	0.8	-	-	1	3.0	-	-	-	-
ИТХ	2	133.2	-	-	1	125.0	1	8.2	-	-	-	-
“Хонгор хот тохижилт” ОНӨААТҮГ	2	4.2	-	-	-	-	2	4.2	-	-	-	-
ОНХС	1	1,354.5					1	1,354.5				
ТЕЗ	1	125.0			1	125.0						
<b>Дүн</b>	<b>8</b>	<b>1,620.7</b>	<b>1</b>	<b>0.8</b>	<b>2</b>	<b>250.0</b>	<b>5</b>	<b>1,369.9</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ЗДТГ	1	191.7			1	191.7		
“Эмт наран” ОНӨААТҮГ	1	2.5					1	2.5
ТЕЗ	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>194.2</b>	-	-	<b>1</b>	<b>191.7</b>	<b>2</b>	<b>2.5</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>	-	-					-	-
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>194.2</b>	-	-	<b>1</b>	<b>191.7</b>	<b>2</b>	<b>2.5</b>

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	2	2			1	1		
2	ОНТС	2	1	1		1			
3	ЗГТС								
4	ОНӨҮГ	2	2			2			
5	ТЕЗ	1	1			1			
	<b>НИЙТ</b>	<b>7</b>	<b>6</b>	<b>1</b>		<b>5</b>	<b>1</b>		